

## “СҮҮ” ХК-ИЙН 2015 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

### Тайлангийн эхний хэсэг

#### 1. Үнэт цаас гаргагчийн нэр, оршин байгаа хаяг:

Нэр: “Сүү” ХК  
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 29 дүгээр хороо,  
Үйлдвэрчний эвлэлийн гудамж-37, “Сүү” ХК-ийн өөрийн байр  
Утас: 70007755  
Факс: 70001901  
Электрон хаяг: [info@mongolmilk.mn](mailto:info@mongolmilk.mn)

#### 2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл:

Улсын бүртгэлийн дугаар: 9010001096  
Регистрийн дугаар: 2077108  
Үйл ажиллагааны чиглэл: Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа  
Хувьцаа эзэмшигчдийн тоо: 341

#### 3. Үнэт цаас гаргагчийн зорилго, үйл ажиллагааны стратеги, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл:

Монгол улсын уламжлалт хэрэглээ сүү, сүүн бүтээгдэхүүнийг орчин үеийн техник технологитой уялдуулж, хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг дээдлэн, хувь хүний эрүүл мэнд, хөгжлийг дэмжих бүтээгдэхүүн үйлдвэрлэн түгээнэ.

#### 4. Үнэт цаас гаргагчийн түүх, тухайн зах зээлд эзэлж буй байр суурь, судалгаа:

“Сүү” ХК нь сүү, сүүн бүтээгдэхүүний хөгжлийг тодорхойлогч, хагас зуун жилийн түүхтэй Монгол улсын Ууган сүүний үйлдвэр юм.

Монгол улсын Ууган үйлдвэр Сүү ХК нь 1958 онд анх нийслэлийн хүн амыг сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангах зорилгоор ЗХУ-ын мэргэжлийн байгууллагын боловсруулсан зураг төслийн дагуу, хоногт 30 тн сүү боловсруулах хүчин чадалтайгаар байгуулагдаж байсан. Эдүгээ хоногт 240 тн сүү боловсруулах хүчин чадалтайгаар 70 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

Өдөр бүр өсөн нэмэгдэж буй хүн амын эрэлт хэрэгцээг хангахын тулд үйлдвэртээ дэлхийн стандартад нийцсэн техник технологийг байнга нэвтрүүлж, бүрэн автомат орчин үеийн үйлдвэрийг цогцлоож чадсандаа бид баяртай байна. Үүний нэг баталгаа нь өндөр шалгуур бүхий, олон улсын чанарын стандарт болох ISO 9001:2008 чанарын удирдлагын тогтолцоог үйлдвэртээ нэвтрүүлэн ажиллаж байгаа юм.

Бид “Малчны хотноос таны гэрт” уриан дор нийт 2500 гаруй малчид фермерүүдтэй хамтран ажиллаж, Монгол улсын хамгийн том сүү бэлтгэлийн нэгдсэн системийг бий болгоод байна.

Монгол улс 2015 онд нийт 55,9 сая толгой мал тоолуулсан бөгөөд үүнээс саалийн үнээ 1,295 мянган толгой байна. Монгол улсад үйлдвэрийн аргаар сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулдаг 20 гаруй жижиг, дунд үйлдвэрүүд байдгаас “Сүү” ХК шингэн сүүний үйлдвэрлэлээр Улаанбаатар хотын нийт зах зээлийн 80 орчим хувийг эзэлж байна.

**5. Үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүнтэй холбогдон үүсч болох эрсдэлийн тухай мэдээлэл:**

2015 онд Япон улстай Эдийн Засгийн Түншлэлийн гэрээг байгуулснаар Монголын экспортын бүтээгдэхүүнүүд татварын хөнгөлөлттэйгээр Японы зах зээлд гарах боломж нээгдсэн. “Сүү” ХК-ийн хувьд Азийн зах зээлд бүтээгдэхүүнээ гаргахад энэхүү гэрээ нэг алхам ойртуулсан юм.

Дотоодын сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээлд өрсөлдөгчид олноор бий болж, компаниуд их хэмжээний хөрөнгө оруулалттайгаар зах зээлд хүрээгээ тэлж байна.

Сүү ХК-ийн хувьд эдийн засгийн хямралтай байсан үед бүтээгдэхүүнүүдийнхээ үнийг 200-250 төгрөгөөр бууруулсан явдал нь хэрэглэгчдийнхээ амьжиргааг дэмжихэд томоохон хэмжээний нөлөө үзүүлсэн үйл ажиллагаа болсон юм.

Мөн “Сүү” ХК 2015 онд хүүхэд багачууддаа зориулан шинээр “Бэни & Бани” нэртэй чипсэн ааруулыг анх удаа үйлдвэрлэж эхэлснээр нийт бүтээгдэхүүний нэр төрөл өргөжсөн.

Цаашид эдийн засгийн өсөлт удаашрах, төгрөгийн ханш сулрах, БНХАУ-ын эдийн засаг муудах, түүхий эдийн үнэ унах, гадаадын хөрөнгө оруулалт багасах, цаг агаарын тааламжгүй байдал үүсэх, 2016 оны сонгуулийн үр дүн гэх мэт хүчин зүйлс “Сүү” ХК-ийн ашигт ажиллагаанд шууд болон шууд бус хэлбэрээр нөлөөлж, эрсдэлд оруулах магадлалтай байгаа болно.

**6. Үнэт цаас гаргагчийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээдийн талаарх мэдээлэл:**

“Сүү” ХК-ийн 344,000 ширхэг энгийн хувьцааг 341 хөрөнгө оруулагчид эзэмшдэгээс хяналтын багцыг 3 хүн доорх байдлаар эзэмшиж байна:

№	Нэр	Эзэмшлийн хувь
1	Д. Ганбаатар	33.06%
2	Д. Жамъян	38.69%
3	Б. Түвшинтөгс	22.06%

**7. Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны танилцуулга:**

№	Нэр	Албан тушаал	Ажлын туршлага
1	Д. Ганбаатар	ТУЗ-ын дарга	Макс Группын Ерөнхийлөгч
2	Д. Жамъян	ТУЗ-ын гишүүн	"Топ Бүлэг" ХХК-ийн захирал
3	Б. Түвшинтөгс	ТУЗ-ын гишүүн	"Ай Эм Пи" ХХК-ийн захирал
4	Д. Цэрэнжигмэд	ТУЗ-ын гишүүн	Макс Группын Ерөнхий захирал
5	Б. Гантулга	ТУЗ-ын гишүүн	"Сүү" ХК-ийн Гүйцэтгэх захирал
6	Д. Уянгалянхуа	ТУЗ-ын гишүүн	"Лежандари Феникс" ХХК-ийн захирал
7	Ц. Соёл-Эрдэнэ	ТУЗ-ын гишүүн	"Макс Моторс" ХХК-ийн Гүйцэтгэх захирал
8	Н. Бадамханд	ТУЗ-ын гишүүн	"Сүү" ХК-ийн ТУЗ-ын гишүүн
9	Ш. Даваалимбэ	ТУЗ-ын гишүүн, хараат бус	"Лежандари Феникс" ХХК-ийн гадаад харилцааны менежер
10	Г. Баяр	ТУЗ-ын гишүүн, хараат бус	"Максиг медиа групп" ХХК-ийн захирал
11	Н. Цэрэндорж	ТУЗ-ын гишүүн, хараат бус	Чөлөөт уран бүтээлч
12	П. Мэндсайхан	ТУЗ-ын гишүүн, хараат бус	"Баян тэгш импекс" ХХК-ийн захирал
13	Л. Ганцрэг	Санхүү эрхэлсэн захирал	Макс Группын Санхүү бүртгэлийн албаны дарга
14	М. Болод	Маркетинг, борлуулалт хариусан дэд захирал	Тесо Корпораци, Жем Интернешнл, Баясах Трейд ХХК-уудад маркетинг, борлуулалтын дарга
15	С. Энхтуяа	Үйлдвэрлэл хариуцсан дэд захирал	"Сүү" ХК, ХХААЯ, "Мерси Кор" ОУБ-д технологич, мэргэжилтэн, зөвлөх

8. **Үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа этгээд, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой хувь хүн, хуулийн этгээдийн нэр:**

<b>№</b>	<b>Нэр</b>	<b>Эзэмшлийн хувь</b>
1	Д. Ганбаатар	33.06%
2	Д. Жамъян	38.69%
3	Б. Түвшинтөгс	22.06%

#### **Тайлангийн хоёр дахь хэсэг**

1. **Тухайн жилийн санхүүгийн тайлангаар өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багассан эсэх талаарх мэдээлэл:**

Компани нь 2015 оны жилийн эцсийн байдлаар өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс их байна.

2. **Үнэт цаас гаргагчийн хуваарилахаар шийдвэрлэсэн болон хуваарилсан ногдол ашгийн талаарх мэдээлэл:**

Манай компани 2011 онд IFC, BIO болон Proparco гэсэн санхүүгийн нэгдлээс нийт 6.0 сая ам.долларын урт хугацаат зээл авч үйлдвэрийн хүчин чадлаа өргөтгөсөн бөгөөд хөрөнгө оруулагчидтай байгуулсан гэрээний дагуу дээрх зээл бүрэн төлөгдөж дуусах хүртэлх хугацаанд ногдол ашиг тараахгүй байхаар үүрэг хүлээсэн болно.

3. **Компанийн тухай хуулийн 87, 89 дүгээр зүйлд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн эсэх талаарх мэдээлэл:**

Тайлант хугацаанд Компанийн тухай хуулийн 87, 89 дүгээр зүйлд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй.

4. **Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайлан:**

2015 онд 17,8 сая литр бүтээгдэхүүн буюу 39,539 сая төгрөгийн бүтээгдэхүүн борлуулж 557,2 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бөгөөд нийт 7,215 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.

2015 онд “Сүү” ХК нь Сэлэнгэ аймгийн Мандал суманд “Макс-Агро” эрчимжсэн мал аж ахуйн цогцолбор фермийг 100 хувийн хөрөнгө оруулалттайгаар байгуулсан. Тус ферм нь анхны сүү, үржлийн чиглэлийн эрчимжсэн мал аж ахуйн ферм юм.

#### **Тайлангийн гурав дахь хэсэг**

1. **Бусад холбогдох мэдээлэл**

“Сүү” ХК нь 2015 оны жилийн эцсийн байдлаар нийт 382 ажиллагсадтай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилласан. 2015 оны 11-р сард Санхүүгийн албаны дарга Н.Бадамханд нь гадаад улсад суралцахаар явсан бөгөөд улмаар Л.Ганцэцэгийг “Сүү” ХК-ийн Санхүү эрхэлсэн дэд захирлаар томилсон болно.

2. **Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдээлэл**

“Сүү” ХК-ийн 2015 оны Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит хурал 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр саналын эрх бүхий нийт 323,754 ширхэг хувьцаа эзэмшигчид оролцож, 94,1%-ийн ирцтэйгээр

хуралдаж, “Сүү” ХК-ийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж, тус дүгнэлтийг хуралд оролцогчид 100%-ийн саналаар баталсан юм.

Мөн дээрх хурлаар Хувьцаа эзэмшигчид компанийн цаг үеийн тулгамдсан асуудлуудын талаар болон цаашдын үйл ажиллагааны бодлого, чиглэлийн талаар ярилцаж, санал бодлоо солилцлоо.

## Сүү ХК

### Санхүү байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

	2013	2014	2015
<b>Хөрөнгө</b>			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	584,177.3	162,862.5	119,723.3
Дансны авлага	7,270,098.0	8,458,172.9	7,732,517.9
Татвар, НДШ-ийн авлага	5,971.4	910,847.5	625,228.1
Бараа материал	5,960,109.7	9,330,276.0	8,801,514.2
Урьдчилж төлсөн зардал тооцоо	6,503,392.5	2,802,382.5	8,201,843.9
Бусад эргэлтийн хөрөнгө	-	302,400.0	340,200.0
<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>20,323,748.9</b>	<b>21,966,941.4</b>	<b>25,821,027.4</b>
Үндсэн хөрөнгө	16,416,871.9	22,418,922.6	28,982,096.4
Биет бус хөрөнгө	13,794.9	43,576.8	10,045.9
Биологийн хөрөнгө	-	2,263,959.1	1,989,039.1
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>16,430,666.8</b>	<b>24,726,458.6</b>	<b>30,981,181.4</b>
<b>Нийт хөрөнгө</b>	<b>36,754,415.8</b>	<b>46,693,400.0</b>	<b>56,802,208.8</b>
<b>Өр төлбөр</b>			
Дансны өглөг	1,249,834.2	1,336,280.9	7,666,161.5
Цалингийн өглөг	97,387.7	142,249.5	149,430.4
Татварын өр	146,450.0	502,905.6	457,795.2
НДШ-ийн өр	-	117,318.5	123,017.9
Богино хугацаат зээл	5,255,090.9	9,876,401.3	8,913,180.3
Хүүний өглөг	172,423.3	236,841.8	394,840.8
Бусад богино хугацаат өр төлбөр	4,432.5	54,343.0	31,380.1
<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>6,925,618.6</b>	<b>12,266,340.5</b>	<b>17,735,806.1</b>
Урт хугацаат зээл	11,995,474.2	13,766,431.1	12,594,887.4
<b>Урт хугацаат өр төлбөр</b>	<b>11,995,474.2</b>	<b>13,766,431.1</b>	<b>12,594,887.4</b>
<b>Нийт өр төлбөр</b>	<b>18,921,092.8</b>	<b>26,032,771.6</b>	<b>30,330,693.6</b>
<b>Эздийн өмч</b>			
Хувийн өмч	2,574,220.6	2,578,020.6	34,400.0
Халаасны хувьцаа	(6,279.8)	(6,279.8)	(6,279.8)
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,129,745.3	1,129,745.3	4,950,142.1
Эздийн өмчийн бусад хэсэг	-	-	3,673,365.9
Хуримтлагдсан ашиг	14,135,636.9	16,959,142.3	17,819,887.0
<b>Нийт эздийн өмч</b>	<b>17,833,323.0</b>	<b>20,660,628.4</b>	<b>26,471,515.3</b>
<b>Өр төлбөр ба эздийн өмч</b>	<b>36,754,415.8</b>	<b>46,639,400.0</b>	<b>56,802,208.8</b>

## Сүү ХК

### Орлогын дэлгэрэнгүй тайлан

/мянган төгрөгөөр/

	2013	2014	2015
<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>33,508,777.0</b>	<b>38,175,849.1</b>	<b>38,977,810.9</b>
Борлуулалтын өртөг	23,004,392.8	26,452,000.5	29,602,946.4
<b>Нийт ашиг</b>	<b>10,504,384.1</b>	<b>11,723,848.6</b>	<b>9,374,864.6</b>
Түрээсийн орлого	49,742.6	591,546.6	457,753.3
Хүүгийн орлого	1,225.5	3,249.6	6,997.3
Борлуулалт, маркетингийн зардал	1,597,571.5	1,892,239.1	2,459,564.7
Ерөнхий ба удирдлагын зардал	1,751,357.8	2,527,662.3	2,561,223.3
Санхүүгийн зардал	1,495,276.1	1,814,275.3	1,827,704.9
Бусад зардал	81,991.0	99,189.5	99,793.0
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(2,049,116.4)	(1,882,793.3)	(823,056.5)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(52,344.3)	(72,740.1)	(52,217.5)
Бусад ашиг (алдагдал)	(186,198.3)	(544,234.8)	(1,250,479.8)
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг</b>	<b>3,341,496.7</b>	<b>3,485,510.5</b>	<b>765,575.6</b>
Орлогын татварын зардал	718,249.2	661,905.1	208,406.9
<b>Татварын дараах ашиг</b>	<b>2,623,247.5</b>	<b>2,823,605.4</b>	<b>557,168.7</b>
<b>Тайлант үеийн цэвэр ашиг</b>	<b>2,623,247.5</b>	<b>2,823,605.4</b>	<b>557,168.7</b>
<b>Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг</b>	<b>7.6</b>	<b>8.2</b>	<b>1.6</b>

## Сүү ХК

### Өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

	Өмч	Халаасны хувьцаа	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		Эздийн өмчийн бусад Хуримтлагдсан ашиг		Нийт дүн
			нэмэгдэл	хэсэг	ашиг	Нийт дүн	
<b>2013 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	<b>2,574,220.6</b>	<b>(6,279.8)</b>	<b>1,129,745.3</b>	-	<b>14,135,636.9</b>	<b>17,833,323.0</b>	
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	(100.0)	(100.0)	
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>2,574,220.6</b>	<b>(6,279.8)</b>	<b>1,129,745.3</b>	-	<b>14,135,636.9</b>	<b>17,833,323.0</b>	
Өмчид гарсан өөрчлөлт	3,800.0	-	-	-	-	3,800.0	
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	-	-	-	-	2,823,605.4	2,823,605.4	
<b>2014 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	<b>2,574,220.6</b>	<b>(6,279.8)</b>	<b>1,129,745.3</b>	-	<b>16,959,142.3</b>	<b>20,660,628.4</b>	
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	(2,574,220.6)	-	(1,129,745.3)	3,673,365.9	303,576.1	303,576.1	
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>34,400.0</b>	<b>(6,279.8)</b>	-	<b>3,673,365.9</b>	<b>17,262,718.4</b>	<b>20,964,204.5</b>	
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	-	-	-	-	557,168.7	557,168.7	
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн	-	-	4,950,142.1	-	-	4,950,142.1	
<b>2015 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	<b>34,400.0</b>	<b>(6,279.8)</b>	<b>4,950,142.1</b>	<b>3,673,365.9</b>	<b>17,819,887.0</b>	<b>26,471,515.3</b>	

# Сүү ХК

## Мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

	2013	2014	2015
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>34,910,073.1</b>	<b>39,321,194.7</b>	<b>44,605,095.6</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний	34,835,870.3	39,193,963.2	44,491,405.6
Буцаан авсан албан татвар	62,368.2	124,894.0	105,080.5
Бусад мөнгөн орлого	11,834.6	2,337.5	8,609.5
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>(33,992,291.7)</b>	<b>(43,174,290.1)</b>	<b>(40,706,340.9)</b>
Ажилчдад төлсөн	(2,588,363.4)	(3,247,593.8)	(3,470,154.0)
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(775,261.9)	(840,394.7)	(1,020,694.3)
Бараа материал худалдан авахад төлсөн	(28,852,178.4)	(37,030,011.7)	(34,595,758.4)
Ашиглалтын зардалд төлсөн	(3,103.8)	(3,321.1)	(11,210.2)
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(5,688.4)	(446.1)	(145.9)
Хүүний төлбөрт төлсөн	(314,989.7)	(1,068,270.1)	(805,126.0)
Татварын байгууллагад төлсөн	(1,304,452.8)	(944,491.8)	(679,737.3)
Даатгалын төлбөрт төлсөн	(13.7)	(46.0)	-
Бусад мөнгөн зарлага	(148,239.6)	(39,714.8)	(123,514.7)
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>917,781.4</b>	<b>(3,853,095.4)</b>	<b>3,898,754.7</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>			
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>1,225.5</b>	<b>3,187.2</b>	<b>2,445.4</b>
Хүлээн авсан хүүний орлого	1,225.5	3,187.2	2,445.4
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	-	-	-
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>1,225.5</b>	<b>3,187.2</b>	<b>2,445.4</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>5,884,703.9</b>	<b>13,406,375.0</b>	<b>7,227,924.6</b>
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	5,877,600.7	13,363,093.3	7,215,281.8
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	7,103.2	43,281.7	12,642.8
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>(6,514,033.6)</b>	<b>(9,977,781.6)</b>	<b>(11,172,263.8)</b>
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	(6,464,292.1)	(9,885,420.5)	(11,135,502.5)
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	(20,788.0)	(5,289.7)	(9,655.4)
Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	(28,953.5)	(87,071.4)	(27,105.9)
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(629,329.7)</b>	<b>3,428,593.4</b>	<b>(3,944,339.3)</b>
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	289,677.2	(421,314.7)	(43,139.2)
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>294,500.1</b>	<b>584,177.3</b>	<b>162,862.5</b>
<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>584,177.3</b>	<b>162,862.5</b>	<b>119,723.3</b>

-----o0o-----